



**ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ИРГЭДЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛД
(ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ)**

С.Анужин¹, Л.Адилбиш², А.Алтантсэцэг², Б.Уламбаяр², П.Одгэрэл³, Н.Зулцэцэг³,
Б.Номингэрэл³

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Эм Удирдлага Технологийн Тэнхим
Adilbish@monos.mn, Умас: 88884002

**THE ISSUE OF PEOPLE WITH DISABILITY:
(PHARMACEUTICAL CARE SERVICES)**

S.Anujin¹, L.Adilbish², A.Altantsetseg², B.Ulambayr², P.Odgerel³, N.Zultsetsetseg³,
B.Nomingerel³

*University of Pharmaceutical Sciences, Department of Pharmaceutical Management and
Technology*

Adilbish@monos.mn, Phone number: 88884002

Introduction

16% of the world's 8 billion people, or more than 1.3 billion, are people with special needs or people with disabilities. Of these, there are unofficial studies that show that there are about 650 million people with disabilities in Asian countries. [1] One of the most common problems faced by people with special needs is that disability service organizations, especially pharmacies, do not have access to complete information on their necessary medications.

According to the 2019 data of the National Statistics Committee [4] in our country, 3.4 percent of the total population or 107.6 thousand are citizens with special needs. Article 1.1 of the Law "On the Rights of Persons with Disabilities" [5] provides for the equal rights of persons with disabilities to participate in social relations, to ensure and implement them, to provide an accessible environment, to create conditions, housing, public buildings, roads, public transport, and information. , communication technology is included as being accessible to people with disabilities. However, health and pharmacy services for people with special needs are very challenging.

The main basis of this research work is to make pharmacy services easier for people with special needs, especially people with speech, hearing, visual, mental, and motor disabilities, and to identify and solve problems.

Methods

The research was carried out in a one-moment model. Based on the General Department of Development of People with Disabilities, data was collected by questionnaire using the minimum sample size calculation, which was calculated as 478 people per 1000 population. Statistical analysis was carried out using SPSS-23 software.

Our survey was conducted between November to December 1, 2022 using a snapshot model. Processing of results was carried out using survey data processing.

Conclusion

1. According to the 2019 data of the National Statistics Committee, 3.4 percent or 107.6 thousand of the total population of our country are citizens with special needs. This information has not been updated for 2021-2022.

Out of a total of 478 people in the survey, 54% were male, while 42.8% of the respondents were 20-30 years old. 48.8% of citizens use pharmacies independently, 42.4% with the help of a guardian, and 8.8% of other citizens use pharmacies. The lack of understanding of drug information on prescription forms affects the physician's prescription, drug information, visual and hearing impairments, and misunderstandings.

2. People with speech, hearing, visual, mental, and motor disabilities face the biggest problem in using the pharmacy. Therefore, it is a priority to make certain innovative changes in order to make pharmacy operations equal to citizens. These include: Prescription forms can be read using technology such as QR and AR on the phone, delivering medication instructions and information in audio form to people with visual and mental disabilities, providing more clear and understandable information to people with speech and hearing disabilities, identifying medications for people with visual impairments, and using drugs correctly. We believe that suggestions and solutions are needed, such as placing names and instructions in braille on product labeling and packaging, implementing stairs and doors for people in wheelchairs or with mobility impairments in accordance with standards in all buildings, and providing seats for stairwells between floors. In most cases, it takes 10-20 minutes for people with disabilities to visit a pharmacy. Some citizens are experiencing delays in services for up to an hour. It can be seen that spending a lot of time to visit a pharmacy is difficult for citizens.

In order to solve this problem, under the supervision of a manager and a pharmacist, a post-graduate student of "Pharmacy" of the "University of Pharmaceutical Sciences" should be created to provide advice and information to citizens and reduce the burden.

Key words: People with special needs, Online Pharmacy, QR (quick...`)

Судалгааны ажлын үндэслэл:

Дэлхий дээр нийт 8 тэрбум хүн амын 16% буюу 1,3 тэрбум гаруй нь тусгай хэрэгцээт иргэд буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг. Үүнээс Азийн улс орнуудад 650 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг гэсэн албан бус судалгаа байдаг. [1] Тусгай хэрэгцээт иргэдэд хамгийн түгээмэл тохиолдож байгаа асуудлын нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх үйлчилгээний байгууллага ба тэр тусмаа эмийн санд өөрийн хэрэгцээт эмийн мэдээллээ бүрэн авч чаддаггүй.

Тусгай хэрэгцээт иргэн бүрийн бэрхшээл харилцан адилгүй. Тухайлбал бие бялдын, мэдрэхүйн эрхтний, оюуны болон сэтгэцийн шинжтэй байж болно.

Тусгай хэрэгцээт иргэн бүрд аливаа үйлчилгээг амар хялбар үзүүлэхийн тулд дэлхийн улс орон бүр судалгаа шинжилгээ явуулж байдаг. Тэр тусмаа Европ болон Азийн өндөр хөгжилтэй орнууд өөрсдийн тусгай хэрэгцээт иргэдэд нийгмийн харилцаанд энгийн иргэд шиг үйлчилгээг авч, харилцах харилцааг бүхий л талаас нь шийдэж өгсөн байдаг. Европын орон болох АНУ-д тусгай хэрэгцээт иргэдэд үйлчлэх чиглэлээр мэргэшсэн эмийн сангүүд байдаг. Зөвхөн тусгай хэрэгцээт иргэдэд зориулж

хамгийн сүүлийн үеийн сав баглаа боодол, түгээлтийн технологийг ашигладаг. Мөн тусгай хэрэгцээт иргэдэд үйлчилгээ үзүүлдэг эмч, сувилагч, эм зүйч наарт эмийн мэдээллийн талаар семинар, хурал, цахим уулзалт зэргийг тогтмол хийдэг байна. [2]

Харин Азийн хамгийн өндөр хөгжилтэй Япон улс нь "Хөгжлийн бэрхшээлтэй хүний дэмжих тухай [3] хууль"-ийн хэрэгжилтээр (2005.04.01) үйлчилгээний байгууллага болох сургууль, цэцэрлэг, эмнэлэг, эмийн сан гэх бүх л нийтийн үйлчилгээнд тусгай хэрэгцээт иргэдийн тулгамдаж буй үйлчилгээний асуудлыг бүрэн хангаж өгсөн байдаг.

Манай улсад Үндэсний Статистикийн Хорооны [4] 2019 оны мэдээллээр нийт хүн амын 3.4 хувь буюу 107.6 мянга нь тусгай хэрэгцээт иргэн байдаг. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" [5] хуулийн 1.1-д хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хүртээмжтэй орчноор хангах, нөхцөлийг бүрдүүлэх, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна хэмээн тусгагдсан байдаг боловч хэрэгжилт сул байсаар байна.

Энэхүү хэрэгжилтийн нэг хэсэг болох тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан эрүүл мэнд болон эмийн сангийн үйлчилгээний асуудал чухлаар тавигдаж байна.

“Тусгай хэрэгцээт иргэд буюу Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” бие даан эмийн сангаар үйлчлүүлэхэд бэрхшээлтэй асуудлууд их байдаг. Тухайлбал ярианы, сонсголын, харааны, сэтгэцийн, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн болон эмийн талаарх мэдээллийг бүрэн олгож чадахгүй байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг байсаар байна.

Иймд дээрх нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын гол үндэслэл болно.

Судалгааны зорилго:

Тусгай хэрэгцээт иргэдийн эмийн сангаар үйлчлүүлэх сэтгэл ханамжийн судалгаа, шийдвэрлэх арга замыг тодорхойлох.

Судалгааны зорилт:

1. Тусгай хэрэгцээт иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах


2. Эм зүйн тусламж үйлчилгээг хүргэхэд тусгай хэрэгцээт иргэдэд тулгамдаж буй асуудлыг тогтоох

Судалгааны материал арга зүй:

Судалгааг нэг агшингийн загвараар хийж гүйцэтгэлээ. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ерөнхий газар”-ыг түшиглэн түүвэрлэлтийн хамгийн бага түүвэр тооцох аргыг ашигласан болно. Сэтгэл ханамжийн судалгааг асуумж болон ярилцлагын аргаар, орчин үеийн цахим системтэй уялдуулан тусгай хэрэгцээт иргэдэд эмийн мэдээллийг ойлгомжтойгоор хүргэх асуудлыг QR (quick response) системд хөрвүүлсэн болно. Статистик боловсруулалтыг SPSS-23 програм ашиглан нэг агшингийн загвараар хийж гүйцэтгэв. Судалгааны data боловсруулалтыг ашиглан үр дүнгийн боловсруулалт хийв.

Судалгааны үр дүн:

Судалгааны материалыг бэлтгэхдээ 17 асуулт бүхий асуумж судалгааг Улаанбаатар хотод байрлах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ерөнхий газар” “Хараагүйчүүдийн төв” зэрэгт хамрагдаж буй 478 иргэнээс авсан судалгаанд боловсруулалт хийж, үнэлэлт дүгнэлт гаргав.



Graphic 1. Main information of research participant



Судалгаа, шинжилгээ

Судалгаанд нийт 478 хүн оролцогчдын 54.2% нь эмэгтэй, 45.8% нь эрэгтэй хүйсийн хүмүүс эзэлж байна. Оролцсон хүмүүсийн насын ангиллыг авч үзвэл 10-20 насын /36%, 20-30 насын /42.8%, 30-40 насын /12%, 45-60 насын /9.2% хүмүүс тус тус хамрагдсан байна. Асуумжид сэтгэцийн болон сонсголын бэрхшээлтэй иргэдэй дийлэнх хувийг эзэлж байна. Тусгай хэрэгцээт иргэдийн эмийн

сангаар үйлчлүүлэх давтамж эрэлт хэрэгцээг судалж үзэхэд бие даан үйлчлүүлдэг иргэд нь 48.8%, асран хамгаалагчийн тусламжтайгаар үйлчлүүлдэг нь 42.4% бөгөөд сард 2-4 удаагийн давтамжаар эмийн тусламж үйлчилгээг авдаг байна. Мөн эм зүйн тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийг үнэлэхэд 42% нь сайн, 35.6% нь дунд, 11.6% нь муу гэсэн хариултыг өгсөн.

**Graphic 2. Needed time for pharmaceutical service**

Тусгай хэрэгцээт иргэдийн эмийн сангаар үйлчлүүлэх хугацаа нь ихэвчлэн 10-20 минутыг /42.4%/ зарцуулдаг бол зарим тохиолдолд 30-аас дээш минутыг /21.2%/ зарцуулдаг бөгөөд

эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад иргэдийн хувьд хүндрэлтэй болох нь харагдаж байна.

Choose from the challenges you face in getting pharmacy services? * What is the level of service received from the pharmacy for the prescription written by the doctor? Crosstabulation

Choose from the challenges you face in getting pharmacy services?	Structure of pharmacy	What is the level of service received from the pharmacy for the prescription written by the doctor?					Total
		Get full service	Normal	Average	Very difficult to get the service	Can't get it at all	
Structure of pharmacy	13	14	15	2	3		47
Ambiguity of drug information on prescriptions	14	77	33	7	0		131

Choose from the challenges you face in getting pharmacy services?	Inadequacy of medicines	2	17	20	5	0	44
	Misunderstanding of relationship with pharmacist and pharmacist	3	5	7	2	2	19
	Availability of pharmacists	3	0	2	0	4	9
	Total	35	113	77	16	9	478

Table 3.satisfaction survey of people with disability

/Хүснэгт 3/-аас авч үзэхэд тусгай хэрэгцээт иргэд эм зүйн тусламж үйлчилгээг авахад хангалттай бүрэн үйлчилгээг авдаг иргэд нь 3% байсан бол жор баригчтай бүрэн харилцах чадвар дутмаг, эмийн заавар мэдээ мэдээлэл хангалтгүй авдаг иргэд 97% -г тус тус эзэлж байна.

Дүгнэлт

- Судалгаанд нийт 478 хүн оролцогчдын 54.2% нь эмэгтэй, 45.8% нь эрэгтэй хүйсийн хүмүүс эзэлж байна. Оролцсон хүмүүсийн насты ангиллыг авч үзвэл 10-20 насты /36%, 20-30 насты /42.8%, 30-40 насты /12%, 45-60 насты /9.2% хүмүүс тус тус хамрагдсан байна. Асуумжаас үзэхэд сэтгэцийн болон сонсголын бэрхшээлтэй иргэд дийлэнх хувийг эзэлж байна. Тусгай хэрэгцээт иргэдийн эмийн сангаар үйлчлүүлэх хугацаа нь ихэвчлэн 10-20 минутыг /42.4% зарцуулдаг бол зарим тохиолдолд 30-аас дээш минутыг /21.2% зарцуулдаг бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад иргэдийн хувьд хүндрэлтэй болох нь харагдаж байна. Мөн эмийн сангаар үйлчлүүлэх сэтгэл ханамжийг үнэлэхэд 42% нь сайн, 35.6% нь дунд, 11.6% нь муу гэсэн хариултыг өгч байгаа нь жорын маягт дээрх эмийн мэдээллийн ойлгомжгүй байдал, эмчийн жор бичилт, эмийн заавар зөвлөгөө, жор

баригч үйлчлүүлэгч хоорондын харилцан үл ойлголцол зэрэг нөлөөлж байна. Эмийн зааварыг тусгай хэрэгцээт иргэдэд зориулан дохионы болон брайл хэлбэрээр хөрвүүлэн нэвтрүүлэхэд “Тусгай хэрэгцээт иргэд буюу Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-д бие даан эмийн сангаар үйлчлүүлэхэд цаг хэмнэсэн, эм зүйч үйлчлүүлэгч хоёрын хоорондын харилцан үл ойлголцлыг залруулан сайжруулснаар нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай ойлголт, урьдчилан сэргийлэлт, эмийн зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд онцгой хувь нэмэртэй гэж дүгнэж байна.

- Судалгааны ажлын хоёрдугаар зорилтын хүрээнд эмийн сангийн үйл ажиллагааг иргэдэд эрх тэгш хүргэхийн тулд тодорхой шинэлэг өөрчлөлтүүд хийх нь нэн тэргүүнд тавигдах асуудал байсаар байна. Үүнд: Жорын маягтыг утасны QR, AR зэрэг технологийг ашиглаж уншуулахад харааны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдэд аудио хэлбэрээр эмийн заавар, мэдээллийг хүргэх, ярианы болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд илүү тод ойлгомжтой мэдээлэл өнгө дүрсээр ялгагдаж харагдах, харааны бэрхшээлтэй иргэдэд эмээ таних, зөв зохистой хэрэглэхэд эм бараа бүтээгдэхүүний хаяглалт, савлагаан дээр брайл үсгээр нэр, зааврыг оруулж өгөх юм. Бидний судалгааны хүрээнд





17 антибиотикийг Qr технологийг ашиглан эмийн зааврыг дохионы хэлэн дээр хөрвүүлэн гар утасаараа хаанаас ч эмийн мэдээлэл

заавар зөвлөмжийг авах боломжтой болгосон ба цаашид эм хангамжийн байгууллагад нэвтрүүлж бүх эмийн мэдээллийг тухайн системд нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн саналыг хүргүүлж байна.

Ном зүй

1. Legalinfo.mn “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ” Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл 1дүгээр зүйл 1.1
2. mnfb.mn “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлага” Хуудас 5

3. mns105.coo.mn “Эмзүйч, эмнайтуулагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” Гурае бүлэг 3.1-3.3.2
4. А.Алтанцэцэг Ш.Оюунбилэг
Н.Бямбасүрэн Б.Уламбаяр Б.Номингэрэл
“Эм зүйн мэргэжилтний гарын авлага” УБ 2021
5. 1212.mn /Үндэсний статистикийн хороо/
“Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүс, аймаг, нийслэлээр”
6. Apdc.mn “Сэтгээцийн болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн онцлог”
7. Mohs.khe.gov.mn /Монгол Улсын стандарт/
8. gadpwd.gov.mn “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай” 5.5

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗҮ-ы доктор, профессор Л.Уламбаяр